

СЭДЭВ: "Нэгж хичээлийг сурагч төвтэй, ялгаатай байдал оролцоонд суурилсан бүтээлч арга зүйгээр төлөвлөх нь"

МОДУЛЬ

Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарт зориулав.



Дэд агуулга 1.

"XXI зууны багшлахуй ба суралцахуйн чиг хандлага"

1.3 "Үндсэн арга зүй болох сургалтын загвар"

Зорилт. Суралцахуйн онолд суурилсан 21-р зууны түгээмэл сургалтын арга зүйг судлах

Хугацаа. 80 минут

Аргачлал. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

Материал. АХБ-ны "Эдийн Засгийн Хүндрэлийн үед Боловсролын Чанар, Хүртээмжийг Сайжруулах төсөл L3594-MON

Шинэ зууны боловсрол, сургалтыг амжилттай зохион байгуулж, ирээдүйд өрсөлдөн амьдрах чадвартай, насан туршийн боловсролтой иргэнийг бэлдэхийн тулд орчин үеийн боловсрол судлал, суралцахуйн онолын үзэл санаа, түүний хөгжлийн чиг хандлагыг танин барьж хэрэгжүүлэх учиртай. Нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн төрөлтхтний өмнө үүссэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор шинэ шинэ үзэл санаа тасралтгүй гарч онол арга зүй улам боловсронгуй болон хөгжсөөр байна.

илэрхийлдэг ухагдахуунуудын утга санаа шинээр баяжин хөгжихийн зэрэгцээ шинэ нэр томьёо, ойлголт ч бий болон хөгжиж байна. Жишээлбэл, дижитал эриний шилжилтээр суралцахуй гэж юу вэ гэсэн ойлголт ихээхэн хувьсан өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ зөвхөн суралцахуйн хэдэн арван тодорхойлолтыг олж жагсаах боломжтой болжээ. Мөн бидний боловсролд хэрэглэдэг нэг нэр томьёог авч үзэхэд судлаачид, улс орнууд олон янзаар хэрэглэж байна. Тухайлбал, кирикюлим (curriculum) гэсэн нэр томьёогоор зарим улс сургалтын төлөвлөгөөг, зарим нь сургалтын хөтөлбөрийг нэрлэдэг байна. Боловсролын нэр томьёоны талаар одоохондоо дэлхий нийтээр нэгдмэл баримталдаг тогтсон дэг жаяг байхгүй, байх боломж ч үгүй юм.

Боловсрол гэж юу вэ?

Боловсролыг "Хүн зөвхөн өөрийн хүч, идэвх чармайлтаар л амьдрах орчноо эзэмдэх бөгөөд боловсрол бол өөртөө эзэн байх чадвар бүхий хувь хүн болж төлөвших үйл явц юм" гэж Германы эрдэмтэн Вилхельм фон Хунболдт (Marianna Wertz, 1996) хүмүүнлэг талаас нь хамгийн оновчтой тодорхойлжээ. Энэ талаас авч үзвэл боловсролын хүмүүнлэг хандлагыг эрчимжүүлэх нь хүүхэд залуучуудын хөгжилд чухал үүрэгтэй болно. Иймд боловсрол олгох аливаа сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх сургалт нь суралцагчдыг өөрсдийнхөө ертөнцийг өөрсдөө бүтээн хөгжүүлэх зорилгод чиглэж, харин сургууль суралцагч бүрийг өөрсдийнхөө ертөнцийг өөрсдөө бүтээн нийгэмшихэд чиглүүлэн хөгжүүлэх газар болж таарч байна. ЮНЕСКО-ийн баримт бичиг (UNESCO, 1997)-т боловсрол бол "суралцахуйн амжилтыг бий болгох зорилго бүхий зохион

байгуулалттай, тасралтгүй явагддаг харилцааны хэлбэр", "Боловсролын тухай дахин эрэгцүүлэн бодох нь" (UNESCO, 2015) номд "урдаас бодож төлөвлөсөн, чиг зорилготой, зохион байгуулалттай суралцах үйл ажиллагаа", боловсролын олон улсын ангилал (UNESCO. 2011)-д "боловсрол нь хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн, урьдчилан нарийвчилж төлөвлөсөн, системтэй үйл ажиллагаанаас бүрдэнэ. Боловсролын үйл ажиллагаа нь эрдэм

мэдлэг (learning) олгоход чиглэсэн зохион байгуулалттай, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоо (communication)" гэж тус тус тодорхойлсон байна.

Суралцахуй гэж юу вэ?

Суралцахуй гэдэг нь шинэ ойлголт, мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил, үнэт зүйлс, зан байдал, сонголтыг туршлага хуримтлуулан суралцах замаар олж авах үйл явц юм. Суралцахуй нь "туршлагын үр дүнд бий болж, гүйцэтгэл, ирээдүйн сурах чадварыг нэмэгдүүлэх боломжийг өөрчлөхөд хүргэдэг үйл явц юм" (Ambrose et al, 2010, p.3). Сурахуй нь хэдийгээр суралцагчид өөрсдөө хийдэг зүйл боловч суралцахуйн онол зарчмын дагуу явагдаж байж сая амжилтад хүрнэ. Сурах чадварыг олон янзаар тодорхойлж болох боловч туршлагаас үүдэлтэй зан үйлийн харьцангуй байнгын өөрчлөлт гэдгийг ихэнх сэтгэл судлаачид хүлээн зөвшөөрдөг. Дижитал эринд сурагч багшгүйгээр сурах боломжтой бол багш нар сурагчгүйгээр багшлах боломжгүй юм.

Сургалт гэж юу вэ?

Сургалт гэдэг нь тухайн хүнд ажил, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай ерөнхий болон тодорхой, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагыг хөтөлбөрийн дагуу олгодог зохион байгуулалттай үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, сургалт бол нэг талаас хэд хэдэн үйл ажиллагааны үр дүнтэй гүйцэтгэлд хүрэхийн тулд хүний мэдлэг, ур чадвар, хандлагыг өөрчлөх, хөгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөөтэй, системтэй хүчин чармайлт юм. Нөгөө талаас сургалт нь тодорхой ур чадварыг товлосон хугацаанд хөгжүүлэх арга юм. Сургалт нь хэрэгцээ, зорилгоос хамаарч маш олон төрөл байна. Суралцахуйн багш төвтэй, суралцагч төвтэй гэсэн хоёр хандлага байдаг. Суралцахуйн хандлага бол сургалтыг нийгэм түүхэн нөхцөлд тохируулан явуулах талаарх судлаачдын үзэл санаа юм.

Сургалтын технологи гэж юу вэ?

Хүмүүс хэрэгцээгээ хангахын тулд хамгийн шинэлэг зүйл, шинэ бүтээл, шинжлэх ухааны нээлтийг ахуйдаа ашиглах бүхий л арга замыг технологи гэнэ. Нөгөө талаас технологи бол "Шинжлэх ухааны болон бусад зохион байгуулалттай мэдлэгийг өдөр тутмын даалгавар биелүүлэхэд ашиглах"-д оролцдог зүйл юм. Аливаа технологи шинжлэх ухаанд үндэслэдэг. Грекээс гаралтай энэ үг "Techne" (чадвар, гар урлал, техник хэрэгсэл) ба "Logos" (заах) гэсэн утгыг агуулдаг. Сургалтын технологи (Learning technology)-ийн үндэс суурь 20 дугаар зууны эхний 10 дахь жилд тавигдсан гэж үздэг (Сеттлер, 1990). Хөгжлийн эхний үед сургалтын технологийг дуу бичлэг, радио дамжуулалт, дуут хөдөлгөөнт зэрэг мэдээллийн хэрэгсэл гэж үздэг байжээ. 1960-аад оноос сургалтын технологийг үйл явц гэж үзэх болов. 1990-д оноос үйл явцаас илүү өргөн ойлголт гэж үзсэн. Сургалтын технологи бол сургалтын үйл явц болон эх үүсвэрийн аргачлал, хөгжил, хэрэглээ, удирдлага болон үнэлгээний онол, практик юм (Сийлс, Ричи, 1994). 21-р зуунд сургалтын технологийг сургалтын дизайн, технологийн салбар гэж нэрлээд мэдээллийн хэрэгслийг сургалтын зорилгоор ашиглах болон сургалтыг аргачлах үйл ажиллагааг системтэйгээр ашиглах дизайн-загварчлал, аргачлалыг хөгжүүлж байна. Сургалтын технологийг дараах түвшинд ялган тодорхойлж болох юм.



Зураг 1. Сургалтын технологи

Боловсролын технологи (Educational technology) нь заах, сурах чадварыг сайжруулах зорилгоор сургалтын орчин, сургалтын материалд дүн шинжилгээ хийх, зохион бүтээх,

боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг судалдаг судалгааны чиглэл юм. Боловсролын технологи нь зохих технологийн үйл явц, нөөцийг бий болгож, ашиглах, удирдах замаар гүйцэтгэлийг сайжруулах, сурталчлахад чиглэсэн судалгаа, ёсзүйн салбар юм (Робинсон ба бусад. 2016). Товчхондоо суралцагчдын боловсролын зорилго, хэрэгцээг хангах, сурч боловсрох хамгийн үр дүнтэй орчныг бий болгож ашиглах юм. Сургалтын технологи нь боломжит арга барил, процедурыг ашиглан багшлах, түүний үйл явцад ашигладаг харилцаа холбоо, мэдээлэл, технологийн хэрэгслийг тодорхойлдог толгой “шүхэр” нэр томъёо юм. "Боловсролын үйл явц" гэж ойлгож болох юм. Судлаачид олон янзаар тодорхойлдог:

- Сургалтын технологи бол сургалтын явцад багшийн зүгээс техник эсвэл мэдээллийн хэрэгсэл ашиглан суралцагчдад нөлөөлөх арга замуудын тухай шинжлэх ухаан
- Хүнийг хүн болгон төлөвшүүлэх өвөрмөц урлаг, танин мэдэхүйн үйлдлийг системчлэх загварчлал
- Багшлах, суралцах, үнэлгээ өгөх үйл дэх технологийн хэрэглээ (сурахад ашигладаг дижитал хэрэгслүүд, мэдээллийн хэрэгслүүд багтдаг)
- Сургалтын аливаа технологи нь суралцагчдад өөрсдийн хариуцлагаа дээшлүүлэх, мэдлэг, чадварыг ангиас гадуур хэрэглэх, дээд түвшний сургалтанд хамрагдах боломжийг олгодог

Сургалтын стратеги гэж юу вэ?

Сургалтын стратеги (Learning Strategies) бол суралцагчдын сурах даалгаврыг биелүүлэх, төлөвлөсөн үр дүнд хүрэх шийдвэрүүдийн багц, сургалтад ашигладаг бодол санаа, үйлдлүүд юм. Сургалтын стратегийг судлаачид олон янзаар ангилсан байдаг. Сургалтын стратегийн шууд (direct strategies) ба шууд бус (indirect strategies) гэсэн ангилал түгээмэл байна. Шууд стратегид санах ойн (memory strategies), когнетив - (cognitive strategies), нөхөн тэнцвэржүүлэх (compensation strategies) орно. Нөхөн тэнцвэржүүлэх стратеги нь суралцагчдын өөрсдийн хязгаарлагдмал талыг нөхөх зорилгоор ашигладаг харилцааны стратеги юм. Ойлгохгүй үедээ утгыг нь тааж, дохио зангаагаар ашиглах нь энэ стратегийн жишээ юм. Шууд бус стратегид метакогнетив (metacognitive strategies), аффектив (affective strategies), нийгмийн (social strategies) стратеги багтдаг. Метакогнетив стратегид өөрийн суралцах хэрэгцээг тодорхойлох, зохион байгуулах, төлөвлөх, удирдах зэрэг, аффектив стратегид сэтгэл хөдлөлөө жолоодох, түгшүүрээ багасгах, өөрийгөө зоригжуулах зэрэг, нийгмийн стратегид бусадтай хамтрах, харилцах, бусдыг өрөвдөн хайрлах зэрэг үйлдлүүд багтана. Сургалтын стратеги нь судлагдахууны онцлогтой хэрэгжих талтай. Нэгэнт арга барил тул өөр өөр өнцгөөс олон янзаар ангилсан байдаг. Багшийн багшлах (сурган хүмүүжүүлэх) стратеги, сурагчийн бие даан суралцах стратеги ч өөр өөрийн онцлогтой. Тухайн даалгаврыг биелүүлэх хувь хүний хандлага сурагчийн сурах стратеги юм. Тиймээс өнөө цагт багш нар суралцагчдад сургалтын хөтөлбөрийн тодорхой агуулга эсвэл тодорхой ур чадварыг заахаас илүүтэйгээр хэрхэн сурах арга барилыг заах нь ач холбогдолтой.

Багш төвтэй болон суралцагч төвтэй сургалтын стратеги мэдээж ялгаатай. Багшийн багшлах арга барил, туршлага нь багшийн сургалтын стратеги юм. Орчин үеийн сургалтад дараах дөрвөн стратегийг голлон хэрэгжүүлж байна. Үүнд:

Зааварчлах стратеги (direct Instruction). Уламжлалт арга ч гэж нэрлэдэг. Голчлон лекц зэрэг багш төвтэй үйлээс бүрдэх тул сургагч идэвхтэй байр суурьтай оролцоно. Суралцах үйл нь ихэвчлэн бодит байдал (факт)-ыг мэдэж авахад чиглэнэ.

Олон талт стратеги (Interactive Instruction). Энэхүү стратеги нь харилцах, хамтрах, хэлэлцүүлэх үйлийн таатай орчин бүрдүүлэхээс эхэлнэ. Суралцахуй нь харилцаа хамтын ажиллагаанд суурилан нээлттэй, хаалттай бүлгийн хэлэлцүүлэг, төслийн хамтарсан ажил, ангийн бүхэл бүтэн хэлэлцүүлэг гэх мэт янз бүрийн хэлбэрээр явагдах боломжтой.

Туршлагад суурилсан стратеги (Experiential learning). Дьюигийн "Туршлага ба боловсрол" бүтээлийн үзэл санаанаас эхлэлтэй юм. Энэхүү стратеги нь сургалтын бүтээгдэхүүнээс илүү суралцах үйл явцын тэргүүлэх чиглэлийг тодотгох, суралцагчдыг өөрсдийн туршлага, урьд өмнө сурч мэдсэн зүйлээ шинэ нөхцөл байдалд хэрхэн хэрэглэх талаар танин мэдэхүй, сэтгэн бодохуйг хөгжүүлэхэд тус тус анхаардаг.

Бие даасан судалгаа (Independent Study). Энэхүү стратеги нь суралцагчийн хувь хүний санаачилга, бие даах чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын олон арга хэлбэрийг ашигладаг. Хосоор хамтарч эсвэл жижиг бүлэгт шинжлэн судалж суралцах үйл явцыг голчлоно.

Сургалтын арга зүй гэж юу вэ?

Сургалтын арга зүй (learning methodology) Сургалтын зорилгод хүрэхэд чиглэсэн багш, суралцагчдын системтэй үйл ажиллагаа болон сургалтын чанарыг сайтар хангахын тулд сургалтын онолыг ашиглан хэрэгжүүлж буй хичээлийн системтэй дидактик (instructional) юм. "Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүй" гэдгийн дор хичээлийг хэрхэн төлөвлөж бэлтгэх, хичээлийг хэрхэн зохион байгуулж явуулах, хичээлийн анализыг хэрхэн хийх гурван үе шат, тэдгээрийн доторх олон талт, өргөн хүрээтэй үйл ажиллагааны аргыг ойлгоно" (Жайка, БСШУЯ. 2007). Жишээлбэл, Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй, мэдээлэл боловсруулж мэдлэг бүтээлгэх арга зүй, контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй гэх мэт.

Сургалтын дизайн гэж юу вэ?

Сургалтын дизайн (Learning Design) нь сурган хүмүүжүүлэх стратегийн хүрээнд суралцагч даалгавар гүйцэтгэхэд туслах, нөөц, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Сургалтын тодорхой зорилт, тодорхой контекст, мэдлэгийн мужид сурган хүмүүжүүлэх загварыг хэрэглэх нь сургалтын дизайн юм. "Сургалтын шаардлагатай зорилтод хүрэх багшлах ба суралцах явцын дарааллыг тодорхойлсон сургалтын бүдүүвч юм" (Conole & Fill, 2005).

Боловсрол болон сургалтын хөтөлбөр хоорондын холбоо уялдаа, тогтолцоот чанар, ул суурь, үндэслэл зэргийг сайтар боловсруулахад чиглэгдсэн журам, дэс дараалалтай арга ажиллагааны тогтолцоог сургалтын дизайн ч гэдэг. Суралцагч төвтэй сургалтын дизайныг сурагч төвтэй сургалтын зарчимд суурилан боловсруулдаг.

Сурагч төвтэй сургалтын дизайн нь дараах төрлүүдтэй. Үүнд:

- Хүүхэд төвтэй дизайн (child centered design). Хүүхдийн эрх, хүүхдэд чиглэсэн хандлагыг хослуулдаг.
- Туршлага төвтэй дизайн (experience centered design). Жишээлбэл, нийгмийн туршлагаас суралцахуй, олбын цикл зэрэг.
- Хүмүүнлэг дизайн (humanistic design). Зорилго нь бүх нийт, хүмүүст зориулж бүтээх явдал юм

5. Арга, аргачлалыг агуулга, идэвхтэй оролцоо, бүтээгдэхүүн зэргийг уялдуулан нийцүүлэх үе



Зураг 2. Сурагч төвтэй сургалтын зарчим

Сургалтын загвар гэж юу вэ?

Ерөнхий утгаараа сургалтын загвар (learning models) гэж шинэ ур чадвар, мэдлэг мэдээлэлд суралцах аливаа үйл ажиллагааны үе шат, хэлбэрийг хэлнэ. Сургалтын үйл ажиллагаа, сургагч багшийн заавар, багш нарын үйл ажиллагааг хэрэгжүүлэх багшийн туршлага юм. Хичээлийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хэрэглэдэг эдгээр загвар нь сургалтын хэв маяг, онол арга зүй, сургалтын стратегийг дагаж олон төрөл, ангилалаар хөгжиж байна. Жишээлбэл, даалгаварт суурилсан сургалтын даалгаварт суурилсан загвар гэх мэтээр.

1. Шинэлэг бүхэллэг, цогц даалгавар харуулах
2. Даалгаврын онцлог бүхий сэдвийн бүрэлдэхүүнийг танилцуулах
3. Даалгаврын сэдвийн бүрэлдэхүүн бүрийг үзүүлж танилцуулах
4. Өөр шинэлэг бүхэллэг даалгаврыг харуулах
5. Өмнө нь суралцсан сэдвийн бүрэлдэхүүн бүрийг даалгавар гүйцэтгэх явцад ашиглуулах
6. Даалгаврын онцлог бүхий нэмэлт сэдвийн бүрэлдэхүүнийг танилцуулах
7. Нэмэлт сэдвийн бүрэлдэхүүн бүрийг ашиглаж буйг үзүүлж таниулах
8. Дараагийн мөчлөгийг давтаж хийх

Жишээ 1. Даалгаварт суурилсан сургалтын нэгэн загвар (Task-Based Learning Models)

Жишээ 2. Сэдэвчилсэн сургалтын загвар (thematic learning model)

Сэдэвт суурилсан сургалт нь академик ур чадварыг ашиглахад сургадаг загвар юм. Хэл, математик, дүрслэх урлагийг сэдвээс үл хамааран ямар ч сэдэвт ашиглаж болно. Бичих, унших, зурах нь сэдэвчилсэн үйл биш, бүгд тодорхой шалтгаан хэрэгцээний үүднээс аль ч хичээлд хийгддэг үйл юм. Сэдэвт суурилсан сургалт нь сургалтын хөтөлбөрийн олон чиглэлийг хооронд нь уялдуулж, нэг сэдвийн хүрээнд нэгтгэн бодит мэдлэгийг харилцан уялдаатай, цогцоор судлуулна. Сэдэвчилсэн сургалт нь уламжлалт сэдэв сэдвээр нь заадаг сургалтаас ялгаатай.

Суралцах явцаа бодит хэрэглээтэй байж, сурсан мэдлэг, чадвараа ашиглан өөрсдийгөө, нийгмээ, дэлхий ертөнцөө, бодит амьдрал дээр өөрчлөлт хийх боломжийг олгоно. Хэрэв хүрээлэн буй орчны бохирдлын талаар судлахыг хүсч байгаа бол зөвхөн шинжлэх ухааны төдийгүй хүмүүстэй холбоотой асуудлууд (нийгмийн судалгаа)-ыг цогцоор авч үзнэ. Таван алхамтай сэдэвт суурилсан сургалтын загварыг жишээлэн танилцуулна(Liu, M.C., & Wang, J.Y. 2010).




Зураг 3. Сэдэвт суурилсан сургалтын загвар

Жишээ 3. Колбын туршлагаар суралцахуйн загвар (Kolb's experiential learning model) Дэвид Колб туршлагын онол, загвараа 1984 онд хэвлүүлжээ. Тус тусдаа сургалтын хэв маяг агуулсан дөрвөн үе шаттай сургалтын мөчлөг бүхий загвар нь үйлийг дахин давтан хийж туршлага хуримтлуулж суралцана гэсэн үзэл санааг агуулдаг бөгөөд Жон Дьюигийн прагматик онолд

суурилсан. Колбын сургалтын загвар нь суралцагчийн дотоод танин мэдэхүйн үйл явцтай холбоотой байдаг. Мөчлөг:

Бодит туршлага - үйл ажиллагааг бодитоор хийнэ. Эргэцүүлсэн ажиглалт - үйл ажиллагааны гүйцэтгэлээ ажиглан ололт, алдаа дутагдал, зөрүүг харгалзан үзнэ.

Хийсвэр концепци бий болох – үйл ажиллагааг хийж буй туршлагадаа онол, аргыг хэрэгжүүлнэ, утга учрыг



ойлгоно. Идэвхтэй туршилтыг төлөвлөх - онол, эргэцүүлээс дараагийн туршлагыг төлөвлөнө.

Зураг 4. Колбын туршлагаар суралцахуйн загвар

Туршлагыг эзэмших хүртэл энэхүү 4 мөчлөгийг дахин давтан хийнэ. Сургалтын мөчлөгт орох цэг (хэв маяг):

- Дивергент. Мэдээллийг төрөл бүрийн эх сурвалжаас нэгтгэж хүлээж авч, үйл ажиллагаанд дурлан орж, концепцийн талаар бодож, бусад суралцагчийг ажиглана.
- Ассимиляци. Хийсвэр үндэслэл болон эргэцүүллийн тусламжтайгаар мэдээллийг

хүлээн авах ба боловсруулдаг. Хийж буй даалгавраа бусад туршлага эсвэл үзэл баримтлалтай холбохыг хүснэ.

▪ Конвергент. Дивергент хэв маягийн эсрэг юм. Онолыг практик дээр хэрхэн хэрэгжүүлэх талаар эргэцүүлэн бодоход дурлана.

Аккомодаци. Даалгаврыг шууд туршиж үзэхийг хүснэ. Ямар нэгэн тодорхой зүйлийг хийх, туршилт явуулахад илүү үр дүнтэй байдаг.

Хичээлийн технологи (анги дахь хичээлийн соёл) гэж юу вэ?

Хичээл нь тодорхой зорилготой, хоорондоо уялдаа холбоотой, үе шатуудтай суралцах үйл явц юм. Суралцахуйн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг боловсролын онолд тулгуурлан суралцахуйн үйлийг хамгийн оновчтой, гүйцэтгэх эрэмбэ, дэс дарааллыг хичээлийн технологи гэж үзэж болно. Д.Карнеги (2001) хичээлийн технологи бол боловсрол дахь 4 дэх хувьсгал гэжээ. Хичээлийн гол суралцах үйл нь “бие дааж бүтээлчээр сэтгэх”, “хэрэгтэй мэдлэг, чадварыг мэдээллийн олон эх үүсвэрээс эрж хайх” гэх мэт суралцагч төвтэй, идэвхтэй суралцахуй байх нь чухал. Хичээлийн технологийг Японы сурган хүмүүжүүлэгч Т.Сакамото (1980) сэтгэхүйн системчлэх аргыг сурган хүмүүжүүлэх ухаанд нэвтрүүлэх гэж тодорхойлжээ. Орчин үеийн хичээлийн шаардлагад “өөрийн хэрэгцээг илэрхийлэх”, “судлах хичээлийнхээ хөтөлбөрийг өөрөө сонгох”, “өөрийн хурдаар сурах”, “нээлттэй, ардчилсан байх”, “сурах үйл ажиллагаа нь бие даасан байх” зэрэг зарчим орж байна. Хичээл нийтлэг болон өөрийн онцлог арга зүйтэй. Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, сэтгэн бодох зэрэг нь нийтлэг арга зүй юм. Байгалийн ухааны хичээлүүд сорил туршилтын, монгол хэл задлан шинжлэх-эвлүүлэн таних, гадаад хэл практик дадал, биеийн тамир-тоглох, биеэр гүйцэтгэх, дүрслэх урлаг урлан бүтээх, бүтээл хийх арга зүйг голлон хэрэглэдэг.

Тэргүүн туршлага (excellent experience) гэж юу вэ?

“Тэргүүн туршлага бол ямар нэг шинэ онол биш харин багш нар сурган хүмүүжүүлэх онол практикийг үр дүнтэй ашиглан бага цаг, бага хүч зарцуулж багшлах явцдаа бий болгосон дээд амжилтад хүрэх шинэ арга, хэлбэр, зохион байгуулалт, сайн үр дүн амжилт, ур чадвар, үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, шинэ санаа, шинэ зүйл агуулсан сургууль, багш нарын бүтээлч эрэл хайгуулын үр дүн юм. Жишээлбэл, Г.Рэнцэндоржийн “Тайлбартай дасгалын арга”-аар монгол хэл бичгийн хичээлийг үр нөлөөтэй заадаг тэргүүн туршлагыг манай орны хот хөдөөгийн олон сургуулийн монгол хэл бичгийн багш нар сонирхон судалж, ажилдаа нэвтрүүлэн бүтээлчээр хэрэглэсэн юм. Өнөө цагт энэ тэргүүн туршлагыг байгалийн ухааны хичээлд хүртэл нэвтрүүлэн амжилтад хүрсэн багш нар байна. Мөн МУИС-ийн ахмад багш У.Доёдын “Математикийн бодлогыг тогтолцооны шинжилгээний аргаар шинжлэх арга”-ыг математикийн хичээл төдийгүй хими, физик зэрэг бусад олон судлагдахууны хичээлд хэрэглэсэн байдаг. Энэ тэргүүн туршлага 21-р зууны сургалтад бүтээлч сэтгэхүй, сэтгэн бодох, тогтолцоотой сэтгэх чадварыг хөгжүүлэхэд улам ач холбогдолтой болж байна. Орчин үед сурган хүмүүжүүлэх тэргүүн туршлага ойлголтыг “шинэчлэгч, инновацитай” холбон бүтээлч эрэл хайгуул, шинэ сэтгэлгээ, өвөрмөц байдал зэргийг агуулсан тийм арга туршлагыг тэргүүн

туршлагат тооцож байна. Шинийг санаачлагчдын арга туршлага нь сурган хүмүүжүүлэх практик болон онол, үзэл баримтлалд шинэ шинэ арга замуудыг оруулж ирж байгаагаараа улам их ач холбогдолтой болж байна.

Сургалтын (хичээлийн арга) арга гэж юу вэ?

Сургалтын арга (Learning methods) гэдэг нь өргөн утгаараа суралцагч, баг эсвэл анги танхимын түвшинд дэх хичээлийн үйл явц, үе шат буюу түүний алхам (үйлдэл)-уудыг хэрэгжүүлэхэд сонгосон арга, хэрэгсэл, нөөц юм. Явцуу утгаараа хичээлийн зорилгод хүрэхийн тулд суралцахуйг хэрэгжүүлсэн дэвшилтэт үйлдэл юм. Бид Данидагийн төслийн үеэс сургалтын олон аргуудыг хэрэглэдэг болсон. Хурдацтай өөрчлөгдөж буй орчин үед тархи, сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэг бүтээлгэх аргууд ч хөгжиж байна. Сургалтын аргуудыг олон өнцгөөс, олон түвшинд ангилсан ангилалууд байдаг. Суралцахуйн дээр өгүүлсэн хоёр хандлагад нийцүүлэн сургалтын аргыг ерөнхий байдлаар уламжлалт болон дэвшилтэт арга гэж ангилдаг. Сайн сургалтын арга бол сурах онол, зарчмуудыг ашигладаг, “хийж сурах” зарчмуудыг ашигладаг, суралцагчийг өсөлт, хөгжилд хүргэдэг, суралцагчдыг “чөлөөлдөг”, сэтгэн бодох, сэтгэх чадварыг өдөөдөг онцлогтой байдаг. Гэвч тухайн аргыг ямар үйл ажиллагаа, үйлдэлд оновчтой сонгож хэрэглэн амжилтад хүрсэн бэ гэдгээр аргын давуу, сул талыг тодорхойлно. Сургалтын нэг тохиолдолд ашиггүй болсон арга нь өөр тохиолдолд маш оновчтойгоор хэрэглэгдэж болно. Жишээлбэл, “Хориотой зүйл” (taboo) арга бол суралцагчдын сэтгэн бодох, нэгтгэх, холбон сэтгэх үйлийг маш сайн дэмждэг дэвшилтэт арга бөгөөд тэдний сонсох, ярих, тайлбарлах чадварыг хөгжүүлдэг. Энэ аргыг хичээлийн эхлэл, бататгах хэсэгт ашиглахад илүү тохиромжтой. Аргын алхам нь 4-5 хэрэглэж болохгүй үгсийн жагсаалт өгнө. Сурагч эдгээр үгсийг ашиглахгүй өгсөн даалгаврыг тайлбарлана (сэтгэн бодох), бусад нь юун тухай ярьж буйг сонсоод таана (нэгтгэх, холбох). Жишээлбэл, гадил жимсний тухайд шар, зөөлөн, сармагчин зэрэг үл хэрэглэх үгийг өгч болох юм.

Сурган хүмүүжүүлэх арга техник гэж юу вэ?

Суралцах явцад хэрэглэгддэг сурган хүмүүжүүлэх арга техник (pedagogical techniques) дэх элемент, арга, арга барил, сценариуд (pedagogical scenario) юм. Энэ нь анги, багийг зохион байгуулах, удирдах, хичээлд сурагчдын оролцоог хэрхэн бий болгох, анги дахь харилцан яриа (Ямар асуултыг хэзээ тавих вэ?, хэнд тавих уу?, хариултыг хэрхэн авах вэ?), самбараа багш хэрхэн хөтлөх, ялгаатай суралцахуйг хэрэгжүүлэх, үйлийг сурагчид гүйцэтгэх тохиромжтой цагийг төлөвлөх, сурагчдыг зөв санаанд хүрэхэд хэрхэн хөтлөх, хэрхэн үнэлэх зэрэг анги дахь янз бүрийн үйл ажиллагааны техник, арга барилууд юм.

Жишээлбэл, анги, багийг зохион байгуулах, удирдахад сурагчид Хосоор эсвэл багаар ажиллах уу, Хэзээ багт хуваах вэ?, Багийн танилцуулгыг хэрхэн хийх вэ?, Хэн танилцуулах вэ?, Хэдэн минут ярих вэ?, Хөнгөн асуултаа асуух уу, сурагчид юу юу гэж хариулах магадлалтай вэ?, Түүнийг хэнээс асуух вэ?, эсвэл анги нийт дотор асуултаа тавих уу?, Дөхүүлэх асуулт шаардлагатай болох уу?, болно гэвэл ямар дөхүүлэх асуулт тавих вэ? гээд олон арга техникийг багш төлөвлөнө. Хэрвээ багаар ажиллуулна гэвэл Багийн хэрхэн хуваарилах вэ?, Багийг хэрхэн байрлуулах вэ?, Баг ямар дүрэм баримтлах вэ?, Багийн хэлэлцүүлгийг хэрхэн явуулах вэ?, Багууд үр дүнгээ яаж бэлтгэх вэ?, Багууд санаа бодлоо хэрхэн нэгтгэх вэ?, Асуултыг яаж тавих вэ?, Багийн үйл ажиллагааны хугацааг хэрхэн хуваарилах вэ? гэх мэт илүү нарийвчилсан асуулт гарч ирнэ.

Ашигласан эх сурвалж

“Багшлахуйн загвар” XXI зууны суралцагчдад зориулан сургалтыг дизайнчлах нь . Клэр Р.Килбэйн, Натали Б.Милман

1. Жайка, БСШУЯ. (2007). Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй. Хими. Зөвлөмж I. УБ
2. Карнеги Д. (2001). Нөхдөө өөртөө татаж хүмүүст нөлөөлөх ёсон. Боть/Цуврал: Дэвт. 1. Хэвлэлийн газар: УБ Интерпресс
3. Ambrose et al. (2010). How Learning Works: Seven Research-Based Principles for Smart Teaching [review]/NormanJournal of Applied Christian Leadership.
4. Conole & Fill. (2005). A learning design toolkit to create pedagogically effective learning activities/ 2005 Journal of Interactive Media in Education 8(1). DOI:10.5334/2005-8
5. UNESCO Institute for Statistics. (2011). International Standard Classification of Education ISCED.
6. Liu, M.C., & Wang, J.Y. (2010). Investigating knowledge integration in web-based thematic learning using concept mapping assessment. Educational Technology & Society, 13 (2), 25–39.
7. Marianna Wertz (1996). Education and Character: The Classical Curriculum of Wilhelm von Humboldt, https://www.schillerinstitute.org/fid_91-96/962_humboldt_education.html
8. McClelland, D. C. (1973). Testing for competence rather than for intelligence. American Psychologist, 1-14
9. Robert, W. (2014). Tuning journal of higher education, Competence-based learning: a global perspective. Competences and learning outcomes: a panacea for understanding the (new) role of Higher Education?
10. Helmut Niegemann, Armin Weinberger. (2020). https://link.springer.com/chapter/10.1007/978-3-662-54368-9_1
11. Robinson, Rhonda; Molenda, Michael; Rezabek, Landra. (2016). Educational Technology/A Definition with Commentary. New York
12. Saettler, P. (1968). A history of instructional technology. New York: McGraw-Hill.
13. Sakamoto T. (1980). Utilization of educational technology. Journal of Educational Technology Magazine.
14. Seels, B.B., & Richey, R.C. (1994). Instructional technology: The definition and domains of the field. Washington, DC: Association for Educational Communications and Technology
15. UNESCO (1997), International Standard Classification of Education, ISCED 1997, http://www.unesco.org/education/information/nfsunesco/doc/isced_1997.htm
16. UNESCO, (2015), Rethinking Education: Towards a global common good?, printed by UNESCO in France

Тэгш хамруулах сургалтын арга зүй (Inclusive methodology)

Д. Мөнхжаргал Ph.D. Судлаач

Тэгш хамруулах боловсролын олон улсын чиг хандлага

1960 онд ЮНЕСКО-гоос батлан гаргасан “Боловсролд ялгаварлан гадуурхалыг тэвчих тунхаг” (Convention against Discrimination in Education) гаргасан нь тэгш хамруулах боловсролыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн анхдагч баримтуудын нэг болсон.

1990 оны Дэлхийн боловсролын чуулганаас “Бүх нийтийн боловсрол” /Education for all/ тунхаглал гаргаж хүүхдийн ялгаатай байдлаас үл хамааран боловсролд тэгш хамруулах, 2000 оны Дакарын тунхаглал нь амьдралын боломж, нийгмийн байдал, алслагдсан болон хүйсийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн байдлаас үл хамааран боловсролд тэгш хамруулах, 2015 оны Инчёны тунхаглал нь боловсролд тэгш шударга хамруулах чанартай боловсролын зорилтуудыг дэвшүүлсэн билээ. 1994 онд ЮНЕСКО-ийн баталсан “Саламанкагийн тунхаг бичиг болон тусгай хэрэгцээт боловсролын үзэл баримтлал” (The Salamanca Statement and Framework for Action on Special Needs Education) нь хүүхэд бүр өөрийн хувийн онцлогтой, сонирхолтой, авъяас чадвартай, хэрэгцээтэй гэдгийг тунхаглан

зарлаж боловсролын тогтолцоо болон үйлчилгээг энэхүү үзэл баримтлалын дагуу өөрчлөн дизайнчлах зорилт дэвшүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлгүй хийгээд бэрхшээлтэй гэж ялгаварлан гадуурхалгүй боловсролд тэгш хамруулах, хөгжлийн төвшний ялгаатай хүүхдүүд хамтдаа суралцах ёстой гэсэн шинэ санааг анхлан гаргасан. Ингэснээр ердийн сургуулийн нэг ангид хөгжлийн бэрхшээлгүй болон бэрхшээлтэй, суралцах боломжоо алдсан, үе тэнгийнхнээсээ захалсан хүүхдүүд хамтдаа суралцах боломж буюу тэгш хамруулах боловсролын шинэ үе эхэлсэн. Энэ үеэс багш бэлтгэх тогтолцоо өөрчлөгдөж хүүхдэд хандах багшийн хандлага, сургалтын арга зүйд өөрчлөлт хийж эхэлсэн. Тэгш хамруулах боловсролыг эрэгтэй, эмэгтэй, үндэсний цөөнх, хөдөөгийн хүүхэд, эрүүл мэндийн асуудалтай хүүхэд, хөгжлийн болон суралцахуйн бэрхшээлтэй бүх насны хүмүүст суралцах тэгш боломж олгохуйцаар сургууль болоод сургалтын төвүүдийг өөрчлөх үйл явц хэмээн тодорхойлсон. Ялгаварлан гадуурхах үзэл, ялгаатай байдалд хандах сөрөг хандлагыг бууруулах үйл явц гэж үзсэн. Сурагчдын ялгаатай байдал, сурах онцлогийн хэв шинжийг хүндэтгэсэн, тэдгээрт тохирсон сургалтын таатай орчин бүрдүүлэх, тэдгээрт нийцэхүйц анги танхимын орчин бүрдүүлэх, сургалтын арга зүй нэвтрүүлэх, ур чадвар эзэмших, түүнийгээ амжилттай хэрэгжүүлэх нь өнөөгийн багш нарын өмнө тавигдаж буй шаардлагуудын нэг юм.

Тэгш хамруулах боловсрол нь дан ганц хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулах хэрэг бус суралцахуйн, амьдралын, нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа болон боловсролын үйлчилгээнд хамрагдсан ч гэсэн өөрт тохирсон чанартай боловсролын үйлчилгээний авч чадахгүй захилагдсан хэсэгт тэгш шударгаар хандах гэсэн өргөн хүрээтэй ухагдахуун болсон гэж дүгнэж болохоор байна. Сургуулийн менежмент, байгууллагын соёл, багшийн хандлага, заах арга зүйгээс шалтгаалан суралцагчдыг ялгаварлан гадуурхах, тэдэнд тэгш шударгаар хандалгүй алагчлах, анги хамт олноосоо захалсан суралцагчид анхаарал хандуулалгүй орхих, сургалтын үйл ажиллагаанд оролцох идэвх сонирхол, оролцооны боломжийг дэмжихгүй байх зэрэг сөрөг үзэгдлийг багасгах шаардлагатай болж байна.

Иймд тэгш хамруулах боловсролыг бодитой болгох нэг хүчин зүйл нь багш нарыг идэвхтэй сургалтын арга зүйгээр дэмжих, тэдэнд идэвхтэй сургалт явуулах чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэж дараахь 10 арга зүйг судалж, сургалтандаа ашиглахыг санал болгож байна.

1. Төсөлд суурилсан сургалтын арга зүй (Project-Based Learning -PrBL)

Н. Мөнхбаяр. БМДИ-ийн суралцагчийн хөгжлийн албаны дарга

Мөнхцэцэг ЕБ-ын “Сакура” сургуулийн захирал

Төсөлд суурилсан сургалтын арга зүй гэж юу вэ?

Боловсрол нь анги танхимын сургалтаас хальж хаанаас ч, хэзээ ч, хэн ч, хэрхэн суралцаж болох боломжийг өнөөгийн мэдээлэл, харилцаа, холбооны технологийн эрин үе бидэнд олгож байна. Өнөөгийн суралцагчдад “21 дүгээр зууны боловсрол”, “21 дүгээр зууны цогц чадамж, ур чадвар” олгох, ялангуяа бүтээлч, шүүмжлэлт буюу эргэцүүлэн бодох сэтгэлгээ, аливаа асуудлыг тогтолцоонд нь харах, сэтгэх, харилцах, хамтран ажиллах, асуудлыг шийдвэрлэх гарцыг хайж олох зэрэг тогтвортой байдлын чадамжуудыг төлөвшүүлэхэд төсөлд суурилсан сургалтын арга зүй (Project based learning-PBL) ач холбогдолтой, үнэ цэнтэй байсаар байна. Төсөлд суурилсан сургалт гэдэг нь үнэн бодит, сонирхолтой асуулт, асуудал бэрхшээлийг судлах замаар түүнд хариу өгөх чиглэлээр урт хугацааны турш ажиллахдаа шинэ мэдлэг олж авах, чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа юм. Суралцагчдын хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд хамгийн үр дүнтэй арга нь тэднийг бие биетэйгээ идэвхтэй харилцах, өөрийн санаа, хийсэн зүйлээ танилцуулах, илтгэх, үйл ажиллагааг зохион байгуулах, асуудлын учир

шалтгааныг эрэлхийлэх, шинжлэх судлах, эргэцүүлэх, бодит амьдралын асуудлыг шийдэхэд татан оролцуулах явдал юм. Эдгээр ур чадварыг төсөлд суурилсан сургалтаар хөгжүүлэх боломжтойг олон судалгааны үр дүн харуулдаг. АНУ-ын эрдэмтэн Томас төсөлд суурилсан сургалт нь бодит орчны асуудалд суурилсан нийлмэл даалгаврыг суралцагчдаар гүйцэтгүүлэх замаар тэдний асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах, шинжлэн судлах чадварыг хөгжүүлэх боломжтой бөгөөд төсөл гүйцэтгэсний үр дүнд бодитой бүтээгдэхүүн, үр дүнг гаргаж түүнээс сэтгэл ханамжийг мэдэрч сурах үйлдээ урам зоригтой байдаг гэж дүгнэжээ.

Төсөлд суурилсан сургалтын арга зүйн онцлог

1. Бодит амьдрал, орчны асуудлыг шийдэх боломжит шийдлүүдийг хайж, суралцагчдын сонирхол, сэдэл тэмүүллийг төрүүлж байдаг.
2. Суралцах үйл ажиллагааны цар хүрээ нэлээд гүнзгий, тэдний идэвх оролцоогшаарддаг, хамтын шийдэлд үндэслэн ажлыг илүү чанартай хийх, сурах боломжийг олгодог.
3. Судлагдахууны интеграцийг ханган суралцагчдын дуу хоолой, сонголтууд нээлттэй байдаг.
4. Сургалтын явцад сурагчдад мэддэг, чаддаг зүйлээ ашиглах боломжийг олгох хэрэгтэй. Сурагчид асуудал шийдвэрлэгч болж хөгжих ёстой. Асуудалтай тулгарсан ч заавал нэг шинэ зүйлийг мэдэж, сурч байдаг гэдгийг ойлгуулах хэрэгтэй.
5. Суралцагчдын оролцоо, шууд туршлага дээр тулгуурладаг сургалтын арга зүй юм.
6. Өмнөх мэдлэг, чадварын хүрээнд асуудалтай тулгарсан ч түүнийг шийдэх явцад ямар нэгэн шинэ зүйл сурч байдаг.

Төсөлд суурилсан арга зүйн 6 алхамт загвар

1. Орон нутгийн хөгжилд саад болж буй асуудлуудыг жагсаан эрэмбэлж, нэн шаардлагатай гэж үзсэн нэг асуудлыг сонгон түүнийг шийдэх ямар хэрэгцээ байгааг илрүүлэх.
2. Судлахаар сонгосон асуудлын шалтгааныг илрүүлэх, холбогдох эх сурвалжийг олох, судлах буюу нөхцөл байдлын талаар ЯАГААД гэсэн асуултын дагуу дүн шинжилгээ хийх
3. Холбогдолтой мэдээ, мэдээллийн жагсаалт гарган хуваарилан ажиллах
4. Асуудлын учир шалтгааныг илрүүлснээр шийдэх арга замыг төлөвлөх, нээлт хийх
5. Хязгаарлагдмал байдал, боломж, үйл ажиллагааг үнэлж дүгнэх замаар тодруулга хийх, илүү сайжруулж эцэслэх
6. Санаагаа эцэслэн боловсруулах, түгээн дэлгэрүүлэх, бусдад санал болгох



Зураг 4.2. Төсөлд суурилсан арга зүйн 6 алхамт загвар

2. Тонгоруу сургалт (Flipped learning)-ын арга зүй

Д.Амартүвшин. МУБИС-ийн МБУС-ийн багш

Тонгоруу сургалт гэж юу вэ?

Суралцагч өөрийн идэвхтэй үйл ажиллагаагаар мэдлэг бүтээх, чадварт суралцах боломжтой аргын нэг бол тонгоруу сургалтын арга юм. Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал өрнөснөөс хойш МХТ-ийг сургалтад нэвтрүүлж, түүний тусламжтайгаар сургалтад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хандлага бий болжээ. Түүний нэг жишээ бол тонгоруу сургалтын арга юм. МХТ-ийн тусламжтайгаар, уламжлалт сургалтын үед ангид хийдэг үйл ажиллагааг гэрт, гэрийн даалгаварт хийдэг үйл ажиллагааг ангид хичээл дээрээ хийх боломжтой сургалтын хэлбэрийг

тонгоруу сургалт гэнэ (Jonathan Bergmann & Aaron Sams, 2012). FLGI эвслээс олон улсын хэмжээнд нэгдсэн ойлголт бий болгох зорилгоор 49 орны 100 төлөөлөгчөөр хэлэлцүүлж, тонгоруу сургалтын тодорхойлолтыг шинэчлэн гаргасан байна. Энэ нь “Тонгоруу сургалт бол багшийг сурагч бүрд хүргэх боломжийг олгодог бөгөөд хичээлийн өмнө хичээлийн агуулга, ойлголтыг танилцуулж, хичээлийн цаг дээрээ суралцагч бүрийг идэвхтэй, практик, инновацлаг хэрэглээгээр чиглүүлж өгдөг юм.” (https://www.flglobal.org/international_definition/) гэсэн тодорхойлолт байна. Тонгоруу сургалтын аргын гол зорилго нь суралцагч төвтэй, мэдлэг бүтээлгэх үйлийг хэрэгжүүлэх, дээд эрэмбийн сэтгэн бодох чадвар шаардсан үйл ажиллагаанд оролцуулах, суралцагчийн өөрийн зохицуулалтыг хөгжүүлэх явдал юм.

Тонгоруу сургалтын онцлог: Ахлах анги болон их дээд сургуулийн сургалтад илүү тохиромжтой боловч судлаачид бүх насны суралцагчийн хувьд үр дүнтэй гэдгийг тогтоосон байна. Учир нь тонгоруу сургалтын үед өөрийн удирдлага, зохицуулалт маш их үүрэг гүйцэтгэдэг. Тонгоруу сургалтын арга нь зохион байгуулалтын хувьд уламжлалт танхимын сургалтаас эрс ялгаатай бөгөөд багш, суралцагчийн үйл ажиллагаа нь нэлээд онцлогтой. Тонгоруу сургалтын үед багшийн үйл ажиллагаа нь дараах онцлогтой.

1. Багш хичээлийн төлөвлөлтийг маш сайн хийх шаардлагатай. Учир нь аль болох богино хугацаатай (Бергманн, Семс хоёр багш видеог 10-аас цөөн минутад багтаавал сайн гэсэн байдаг) танилцуулга видео бэлтгэж, түүнд зайлшгүй байх агуулга, зааврыг тусгахын тулд хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтыг маш чамбай хийхийг шаардана.
2. Багшаас камер, микрофон, видео контент бэлтгэх программ хангамж, ухаалаг самбар эсвэл таблет, ухаалаг үзэг, компьютер, видеогоо байрлуулах албан ёсны платформ, түүн дээрх хаяг зэргийг шаардана.
3. Багш нар хамтарч ажиллаж болно. Агуулгын боловсруулалт, видео бичлэг, засвар зэргийг хамтран хийвэл богино хугацаа зарцуулж, илүү чанартай контент бэлтгэх боломж үүснэ.
4. Хичээлийн агуулга, зааварчилгааг сурагчдад танилцуулахаас өмнө сайжруулах, алдаа байвал залруулах боломжтой.
5. Суралцагч бүрийн онцлогт тохирсон арга зүйг технологийн тусламжтайгаар хэрэгжүүлж, ялгаатай суралцахуйг дэмжих боломжтой.

Суралцагчийн үйл ажиллагааны хувьд дараах онцлогийг нэрлэж болно.

1. Өөрөө хичээлээ хийх шийдвэрээ гаргаж, өөрөө өөрийгөө удирдаж суралцана.
2. Багштай болон, бусад суралцагчтайгаа уламжлалт сургалтаас илүүтэй харилцана.
3. Өөрийн хурдаар видеогоо үзэх боломжтой. Зогсоож, удаашруулж, томруулж үзэж болно. Дууг нь чангалж, намсгаж болно.
4. Дахин дахин үзэж болно. Багш нэг удаа хэлээд өнгөрөх бол видеог хэдэн удаа ч үзэж болно.
5. Нэг багш-нэг суралцагч гэсэн харилцаа өрнөдөг. Уламжлалт хичээл дээр нэг багш-нийт суралцагч гэсэн харилцаа зонхилдог.
6. Сурах арга барилд суралцдаг.
7. Дижиталаар суралцах хэв маягт нийцнэ.
8. Хичээлд суух боломжгүй, тэмцээн уралдаанд оролцож байгаа зэрэг шалтгаантай хүүхдүүд хичээлээ нөхөж судлах боломж бүрдэнэ. Ер нь суралцагч багшийн өгсөн зааварчилгааг боломжтой цагтай үзэж танилцана.

Давуу тал	Сул тал
- Суралцагч төвтэй, бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой - Суралцагчийн өөрийн зохицуулалт, өөрийн жолоодлоготой суралцахуйг дэмждэг - Суралцагч өөрийн суралцах онлог, өөрийн хурдаар суралцах боломжтой - Эцэг эхийг хамтдаа суралцах боломж олгож байгаагаараа хичээлийн үр дүнд зэрэг нөлөө үзүүлнэ - Танхимд суралцах боломжгүй суралцагчдад хичээлээ судлах боломж олгоно - Суралцагч сурах арга барилд суралцдаг - Багш нар хамтарч ажиллах нөхцөл бүрдэнэ.	- Багшаас МХТ-ийн чадвар, тоног төхөөрөмж шаардана - Хичээлийн хөтөлбөрийг маш сайн боловсруулахад цаг зарцуулахыг шаардана - Суралцагчаас интернет орчин, багшийн бэлтгэсэн материалтай танилцах төхөөрөмж, түүнийг ашиглах чадвар шаардана. - Суралцагчийн өөрийн удирдлага, зохицуулалт зэрэг метакогнитив чадварын хөгжлийг шаарддаг.

3. Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүй (Problem-Based Learning - PBL)

Асуудал Шийдвэрлэх Сургалтын арга зүйн хэрэгцээ, шаардлага

21 дүгээр зууны боловсролыг судлаачид хүний оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэх нь зүйтэй гэж үзсэн байдаг. Нэгэн их сургуулийн оюутан багшаасаа ямар ажил, мэргэжил ирээдүйтэй тухай асуухад багш: “Бүх ажил мэргэжил ирээдүйгүй. Харин чи ямар ажилсонирхолтой гэж бодож байна, түүнийгээ л судла. Чухамдаа 21 дүгээр зуунд бүх ажил мэргэжил ирээдүйгүй. Харин карьераа хөгжүүлэх, бүтээлчээр суралцах оюун ухааны чадамж бүхий, няцашгүй хүсэл эрмэлзэлтэй хүнд л ирээдүй байх болно” гэж хариулжээ. Нэрт сэтгэл зүйч Ховард Гарднер оюун ухааныг хэн нэгний тодорхой нөхцөл, соёлын хүрээнд өөрт тулгарсан асуудлыг шийдвэрлэх чадвар юм гэж тодорхойлсон байдаг. Боловсролын ач холбогдлыг ойлгохын тулд багш сурган хүмүүжүүлэгч та бүхэн 3P (Paradigms, Philosophy, Practicality) гэж нэрлэгдэх үндсэн асуудлуудын талаар эргэцүүлээд нэг бодоорой. Энэ нь

- Парадигм (Paradigms-Ертөнцийг үзэх таны үзэл юу вэ?)
- Философи (Philosophy-Таны итгэл үнэмшил юу вэ?)
- Практик хэрэглээ (Practicality-Та юу хийх вэ?)

Бид хаанаас ирсэн, хэрхэн өдий хүртэл явж ирсэн болон ирээдүйг хэрхэн харж байна вэ гэдгээ бодох хэрэгтэй бөгөөд юмыг бүхэлд нь том зургаар нь харж сурах хэрэгтэй байна.

Өнөөдөр бид мэдлэг болон технологийн хувьд урьд өмнө тохиолдож байгаагүй онцлог бүхий шинэ мянганд амьдарч, ажиллаж байна. Иймээс бид энэ шинэ мянганд амьдрах иргэдийг шинэ ертөнцөд үр дүнтэй амьдрахад шаардагдах олон талт оюун ухааны чадамжтай болгон бэлтгэх хэрэгтэй байна. Мэдлэг дамждаг гэж үзэх уламжлалт үзэл санаа нь уг хэрэгцээг хангахад хүрэлцээтэй биш юм. Боловсрол бол иргэдийг ирээдүйд бэлтгэх төдий бус харин ирээдүйг бүтээхэд бэлтгэх тухай болж өөрчлөгдөх хэрэгтэй байна.Мэдээлэл харилцааны технологи, интернетийн давуу тал, ач холбогдлоос шалтгаалан өнөөдөр боловсролын талаарх ойлголт эрс өөрчлөгдөж байна. Иймд бид сурагчийн мэдлэг эзэмших, суралцахуйд оролцох талаарх ойлголтоо өөрөөр харах хэрэгцээ шаардлага үүсч байна. Багшийн гол үүрэг болох сурагчдад мэдлэг түгээх нь интернетийн эрин зуунд гол биш болох магадлалтай. Учир нь сурагч мэдээллийг хэзээ ч хаанаас ч олж авах боломж нэгэнт бүрдээд байна. Иймд МХТ, интернетийн хөгжил нь багшаас хөтөлбөр, арга зүй, агуулгаа өөрчлөхийг шаардаж эхлээд байна.

Багш бол зөвхөн мэдлэг, мэдээлэл дамжуулагч биш, мөн суралцахуйг удирдан чиглүүлэгч болж байна. Суралцахуй нь зөвхөн анги танхим дахь үйл ажиллагаа, хичээлийн хугацаагаар үл хязгаарлагдаж эхэллээ. Боловсрол нь илүү бүтээлч сэтгэлгээ бүхий дээд эрэмбийн сэтгэх чадвартай хувь хүнийг бий болгоход дэмжлэг үзүүлэх ёстой. Сургууль тухайн зааж буй агуулгын мэдлэг нь хэр зэрэг хурдан хуучирч, хэрэгцээгүй болж байгаад анхаарал хандуулалгүй заасаар л байвал боловсрол уналтад ордог. Мөн суралцагчийн насан турш

суралцахуйд хувь нэмэр болохооргүй суралцахуйн процессийг хэрэглэсээр байвал багшлах үйл явц уналтад орно.

Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүй, онцлог, давуу тал

Асуудал шийдвэрлэх арга зүйг судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна.

✓ Суралцагч төвтэй, багш удирдан чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг, шинжлэн судлах үйл ажиллагаа голлосон сургалт бөгөөд судлах ёстой агуулгаас давж судалдаг. Энэ сургалт нь суралцагчдын оролцоо болон туршлагад үндэслэн ойлголт эзэмшүүлдэг ба сурагчийн агуулга эзэмшилт урт хугацаанд хадгалагддаг байна. (David W.Mogk, 2004)

✓ Багуудад тодорхой контекст бүхий нөхцөл байдал танилцуулж, асуудлыг тодорхойлох, асуудлыг шинжлэн судлахад ямар нөөц хэрэглэгдэхүүн, чадвар шаардлагатайг шийдэх, боломжит шийдлүүдийг олох үйл ажиллагаа (Duch, Groh, and Allen, 2001)

✓ АШС арга зүй нь сурагчийн цээжлэх

тогтоохоос илүү биечлэн суралцахад анхаардаг арга зүйн нэгэн хувилбар. АШС арга зүйн үед задлан шинжлэх, үнэлэх, зэрэг танин мэдэхүйн дээд түвшний чадвар шаарддаг.

✓ АШС арга зүй нь сурагчдад суралцахад суралцах, бодит амьдралын асуудлын шийдлийг хайхад багаар хамтран ажиллах сургалтын арга зүй юм.

Асуудал Шийдвэрлэх Сургалтын арга зүйн загвар

Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүйг сургалтдаа хэрэгжүүлэхийн тулд ямар үйл ажиллагаа явуулах талаар мэдэх шаардлагатай болно. АШС арга зүйн загварыг судлаачид янз бүрээр тодорхойлж, хэрэгжүүлж ирсэн байдаг. Жишээ болгон зарим загварыг хэлэлцье.

Загвар 1. АШС арга зүйн цикл (UK Centre for Legal Education, 2010)

Энэ загварын хувьд асуудлаа танилцуулаад, уг асуудлыг шийдэхэд шаардлагатай, мэдэх шаардлагатай зүйл юу болохыг тодорхойлох, мэдэхгүй зүйлээ мэдэж авах, уг мэдлэгээ ашиглан асуудал шийдэх гэсэн үндсэн дарааллыг тусгажээ.



4. Үзэгдэлд суурилсан сургалтын арга зүй

(Phenomenon-Based Learning -PhBL)

А. Энхтогтох (Боловсролын хүрээлэн. БХСС-ын эрхлэгч)

Үзэгдэлд суурилсан сургалт гэж юу вэ?

Үзэгдэлд суурилсан сургалт (Phenomenon based learning) нь сургалтын интеграцчлалыг дэмждэг арга зүй юм. Үзэгдэлд суурилсан сургалт нь шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, төсөл болон портфельд суурилсан суралцахуй тэдгээрийн практик хэрэгжилтийг дэмждэг (Silander, 2015).

"Үзэгдэл" гэдэг нь орчлон ертөнцөд болж буй ажиглагдахуйц баримт эсвэл үйл явдлыг хэлдэг. Байгалийн болон хүний бүтээсэн ертөнцөд өдөр бүр янз бүрийн үзэгдлүүд ажиглагдаж, биднийг гайхах эргэлзэх, асуулт асуухад хүргэдэг. Гэхдээ үзэгдэл бүхэн гайхалтай байх албагүй. Шинжлэх ухааны нүдээр харахад ихэнх тохиолдолд энгийн үйл явдлууд ч хүн бүрийн сонирхлыг татаж, хариулт хүлээж байдаг. Энэ нь учир шалтгааныг хайх, судалж шинжлэх эхлэлийн цэг болдог.

Үзэгдэлд суурилсан сургалтын сэдэв нь бодит ертөнцийн асуудал эсвэл "үзэгдэл" байх ёстой бөгөөд тухайн сэдвийг судлахын тулд сурагчид өөр өөр хичээл хоорондын мэдлэг чадвараа цогцоор нь ашиглах хэрэгтэй гэсэн үг юм. Жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуултыг ойлгох, шийдвэрлэхийн тулд шинжлэх ухаан, газарзүй, математик, түүх зэрэг янз бүрийн судлагдахууны мэдлэг шаардагдана гэсэн үг. Үзэгдэлд суурилсан сургалт нь дэлхийн глобал асуудал, салбар дундын хандлага (interdisciplinary approach 1)-д суурилсан байна. Сурагчид сонирхол татсан үзэгдлээ асуулт болгон хувиргаж, түүндээ өөрсдөө хариулахын тулд бүтээлч эрэл хайгуул хийх, шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх зэргээр хэрэгждэг суралцагч төвтэй, олон талт (multidisciplinary instructional approach2) суралцахуйн арга зүйн нэг хандлага юм.

Бид яагаад үзэгдэлд суурилсан сургалтыг хэрэгжүүлэх ёстой вэ?

Сурагчдад өөрсдөө учрыг нь олж, шийдвэрлэх арга замыг нь тодорхойлох шаардлага тулгардаг тул тэд үзэгдэлд суурилсан хичээлд идэвх санаачилгатай оролцдог. Тэд өөрсдөдөө хамааралтай зүйл дээр ажиллаж байгаа тул сурах үйлээ өөрсдөө зохион байгуулна. Ингэхдээ хичээл хоорондын хил хязгаарыг давж, өөр өөр өнцгөөс судлан шинжилж, эцэст нь цогц байдлаар нэгтгэн тайлбарладаг. Сурагчид шийдлийг өөрсдөө тодорхойлж, үзэгдэлд хариулахын тулд өөртөө шинэ мэдлэгийг бий болгож, судалж буй зүйлийнхээ талаар гүнзгий ойлголттой болдог. Үүний үр дүнд тэд таны бодож байгаагүй шийдлүүдээр таныг гайхшруулж ч чадна.

Сурагчид хамтдаа үзэгдлийг ажиглах, үзэгдэл хэрхэн, яагаад үүссэнийг шинжлэн судлах, турших, тайлбарлах таних явцад 21-р зууны иргэний эзэмшсэн байвал зохих багаар ажиллах, харилцах, асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх гэх мэт чадваруудыг эзэмших боломж бүрддэг төдийгүй шинжлэх ухаанч арга барил, хандлагыг төлөвшүүлэхэд түлхэц болдог.

Багш тэдний үйл явцыг удирдан чиглүүлж, ээдрээ төвөгтэй байдалд удаж гацахаас сэргийлж, шат шатаар ахихад нь тусална.

1. Өөр өөр салбар, судлагдахуун хоорондын холбоо, тэдгээрийн бодит ертөнцийн зүй тогтол, хамаарлыг холбож өгдөг арга
2. Судлах сэдэв, шийдэх асуудлыг өөр өөр судлагдахуун/хичээлийн үүднээс судалдаг.

Үзэгдэлд суурилсан сургалтын зорилго, онцлог

Уламжлалт сургалтаар багш нь сурагчдад мэдлэгийг зааж өгдөг тул сурагчдын зүгээс идэвхтэй оролцоо байдаггүй, сонсогчийн зүгээс ханддаг. Хичээлийн агуулга салангид сэдвүүдэд чиглэгдэж, сурагчдад янз бүрийн сэдвийн онол, үзэл баримтлалыг заадаг боловч бодит амьдралд хэрхэн холбогдож нэгдэхийг ойлгуулж чаддаггүй. "Зөвхөн унших эсвэл онолын түвшинд сурч мэдэх нь мэдээллийн талаар бүрэн ойлголт өгөхгүй харин өнгөц, тусдаа дэлгэрэнгүй мэдээлэл хэвээр үлддэг" (Silander. 2015) Тэгвэл үзэгдэлд суурилсан сургалтын зорилго нь сурагчдыг бодит амьдрал дээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бэлтгэдэг. Хийсвэр эсвэл салангид ойлголтуудыг идэвхгүй сурахын оронд бодит амьдралд тулгарч буй бэрхшээлийг гаргаж, түүнийг шийдвэрлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг олж нээх боломжийг сурагчдад олгодог. Өөрөөр хэлбэл бодит нөхцөл байдалтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд сурагчдыг идэвхтэй татан оролцуулж, олон төрлийн шинжлэх мэдлэг, ойлголтыг холбож ойлгоход тусалдаг.

Иймд үзэгдэлд суурилсан сургалт нь тодорхой суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэдэггүй тул уламжлалт анги танхим ба дижитал сургалтаас ялгаатай. Гол ялгаа нь ердөө сурагчдад эзэмшүүлэх арга барилд байгаа юм. Тэрхүү арга барил нь асуудлыг шийдвэрлэх, багаар ажиллах, бүтээлчээр сэтгэх зэрэг нь ангид сууж багшийн яриаг сонсох эсвэл цахим сургалтын видео бичлэг унших, үзэх зэргээр хөгжүүлэх чадвар биш юм. Эдгээр чадварыг үзэгдэлд суурилсан сургалтын гол шаардлага болох идэвхтэй оролцоо ба үйл ажиллагаагаар бий болгодог.

Үзэгдэлд суурилсан сургалтын онол, загвар

Үзэгдэлд суурилсан суралцахуй нь цоо шинэ санаа биш юм. Эх үндэс нь конструктивист сургалтын онол юм. Энэ онолын үзэл санаа нь сурагч өөрийн одоогийн болон урьдын сурч мэдсэн зүйл, ойлголт дээрээ тулгуурлан шинэ санаа бодол, мэдлэгийг бий болгох идэвхтэй үйл гэж үздэгт оршино.



Зураг 2.1. Үзэгдэлд суурилсан сургалтыг төлөвлөх загвар³

1-р үе шат: Үзэгдлийг танилцуулах

Үзэгдэлд суурилсан арга зүй нь сурагчдад үзэгдлийг илрүүлэх, танилцуулахаас эхэлдэг.

Мэдрэхүй болон технологийн төхөөрөмжийг хэрэглэн ажиглаж болох, шууд хэмжиж, туршиж болох аливаа объект, үйл явдлыг үзэгдэл гэнэ.

Үзэгдлийг сонгох шалгуур:

- Сурагчид тухайн үзэгдлийг анги, лаборатори, гадаа орчноос мэдрэх эсвэл хэн нэгний туршлагаас буюу видео танилцуулга, өгөгдлүүдэд дүн шинжилгээ хийх зэргээр ажиглаж, судлах боломжтой эсэх
- Сурагчид энэ үзэгдэл хэрхэн, яагаад тохиолддогийг тайлбарлахын тулд гол

ойлголт, шинжлэх ухаан, сорилт туршилт, хичээл хоорондын холбоо зэргийг ойлгож, ашиглах боломжтой эсэх

- Үзэгдлийг ойлгосноор сурагчид тухайн ангийн түвшний хүлээгдэж буй гүйцэтгэлийн үр дүнд чиглэсэн ойлголтыг эзэмшиж чадах эсэх
- Сурагчдын үзэгдэлд хийсэн тайлбар нь тухайн ангийн түвшинд тохирсон эсэх
- Үзэгдэл нь бодит асуудал эсвэл тухайн орон нутгийн орчинтой холбоотой эсэх
- Сурагчид тухайн үзэгдлийг сонирхолтой бас чухал гэж үзэх эсэх
- Үзэгдлийг нотлох тайлбарлахад шаардагдах зардал, хичээлийн цаг хангалттай эсэх

Сурагчид тухайн үзэгдлийг анги, ахуй амьдрал, хүрээлэн буй орчин эсвэл багшийн харуулсан зүйлээс шууд ажиглаж болно. Мөн үзэгдлийг янз бүрийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж авч болно. Эхний ажиглалтын дараа сурагчид юу бодож байгааг, яагаад ингэж бодож байгааг тэдний асуултаас эсвэл зураглалаас, мөн тэдний гайхаж байгаагаас харж болно. Энэ үе шатанд багш тухайн үзэгдлийн талаарх сурагчдын өмнөх мэдлэг болон тэдэнд ташаа ойлголт байгааг ажиглана. Энэ үе шат нь 5E суралцахуйн загварын оролцох (engage) үе шаттай тохирдог. J. Spiegel, C. Cochrane, J. McCluan, C. Howe, M. Goodbody. San Diego County Office of Education

2-р үе шат: Үзэгдлийг судлах

Эхний үе шатны дараа сурагчид үзэгдлийг цаашид ажиглах, шинжлэн судлах, илрүүлэх боломжтой байх ёстой. Эхний туршилт дээр сурагчид тестийн асуулт боловсруулах, шинжлэн судлах ажлаа төлөвлөж, өгөгдлийг тэмдэглэн, дүн шинжилгээ хийж болно.

Багш өөрийн туршлагад үндэслэн сурагчдаар бусад эрдэмтдийн хийсэн өгөгдөлд дүн шинжилгээ хийлгэж болно. Ийм тохиолдолд өгөгдлийг хаана, хэрхэн цуглуулсан талаарх мэдээллийг өгөх ёстой. Энэ үе шат нь 5E-ийн суралцахуйн загварын шинжлэн судлах (explore) үе шаттай тохирдог.

3-р үе шат: Үзэгдлийг тайлбарлах

Сурагчид ажиглалт болон шинжлэн судлах явцад нотлох баримт цуглуулсан бол загвараа боловсруулж, эхний тайлбараа хийж эхэлнэ. Энэ үеэр сурагчид өөрсдийн нотолгоонд суурилсан тайлбарт нэмэлт нотолгоо болгон ашиглах зорилгоор янз бүрийн текст, мэдээллийн хэрэгсэл, хэлэлцүүлгийг ашиглан аливаа үзэгдлийг тайлбарлах, шинжлэх ухаанд тулгуурласан шинжлэх ухааны санаа, ойлголтыг олж авдаг. Сурагчид өөрсдийн боловсруулсан загвараа ашиглан, нотолгоонд тулгуурлан санаагаа тайлбарлаж, тухайн хичээл болон хичээл хоорондын гол ойлголтуудаа ашиглан, үзэгдэл хэрхэн, яагаад тохиолддог болохыг тайлбарлана. Энэ үе шат нь 5E суралцахуйн загварын тайлбарлах (explain) үе шаттай тохирдог.

4-р үе шат: Тайлбарыг нягталж, хянах

Сурагчид тайлбар, загвараа хуваалцахдаа өөрсдийн санаа бодлыг дахин сайжруулахын тулд ангийн дунд маргаан, шүүмж өрнүүлдэг. Энэхүү хэлэлцүүлэг нь эргээд үзэгдлийг судлах 2-р үе шат руу буцааж дараагийн шинжлэн судлах ажилд хөтөлж магадгүй юм. Үзэгдлийг тайлбарлах 3-р шат ба тайлбарыг нягталж, хянах 4-р үе шат нь ихэвчлэн хоорондоо холбоотой, учир нь эдгээр үе шатанд зааварчилгааны зорилго нь нотолгоонд суурилсан тайлбарыг боловсруулж нягтлах, шинэ нотлох баримтад үндэслэн дахин сайжруулах явдал юм. Энэ үе шат нь 5E суралцахуйн загварын нарийвчлах (elaborate) үе шаттай тохирдог.

5-р үе шат: Тайлбарыг үнэлэх

Энэ үе шатанд сурагчид тайлбараа бичвэр, зураг, хүснэгт диаграмм, графикаар илэрхийлнэ. Сургалтын явцын үнэлгээ нь сурагчийн сургалтын туршид явагддаг чанарын өндөр түвшний даалгавруудад хэрхэн оролцсон байдлаар гарна. Мөн энэ үе шатанд сурагчдын гаргаж буй тайлбарт эцсийн үнэлгээ өгнө. Сурагчид бүтээгдэхүүн үзэгдлүүд хэрхэн, яагаад гарч байгааг бусад сурагчдад тайлбарлана.

Ийм тайлбарыг гаргаснаар сурагчид хичээлийн үндсэн санаа ба хичээл хоорондын үзэл баримтлалын талаарх өөрсдийн ойлголт болон тайлбараа дэмжих баримт нотолгоог үзүүлж, сургалтын туршид сурч мэдсэн зүйлээ харуулдаг. Энэ үе шат нь 5E суралцахуйн загварын үнэлэх (evaluate) үе шаттай тохирдог.

Хүснэгт 2.1. Үзэгдэлд суурилсан суралцахуйн үйлүүд (5 үе шатаар)

Сурагч	Багш
1. Бодит амьдралтай холбоотой үзэгдлүүдээс өөрийн сонирхлыг татсан асуулт тавих.	1. Бодит ертөнцөөс амьдрал, үйл явдлуудтай холбоотой "үзэгдэл" -ийг сонгох
2. Сонгосон сэдвийг өөр өнцгөөс нь судалж шийдлийг олохын тулд судалгаанд оролцох	2. Сонгосон сэдвийн эргэн тойронд "яаж", "яагаад" эсвэл "хэрвээ?" гэсэн лавлах асуултуудыг сурагчдаас асуух
3. Сурагчид цуглуулсан мэдээлэлд үндэслэн тайлбар хийх	3. Сурагчийн сонгосон асуултад хамаарах үндсэн ойлголтуудыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах мэдлэг, чадварыг эзэмших (вэбэд суурилсан судалгаа, танхимд хийх судалгаа, онлайн сургалтын нөөц)-д чиглүүлж, үйл явцыг хөнгөвчлөх
4. Сурагчид өөрсдийн шийдлээ нягталж хянах	4. Сурагчдад шаардлагатай судалгаа, асуудлыг шийдвэрлэх цаг хугацааны баримжаа баталгааг тооцох
5. Сурагчид өөрсдийн шийдлээ сонгосон хэлбэрээр танилцуулах	5. Сурагчдын үйл явцыг удирдан чиглүүлэх, асуудлыг шийдвэрлэх өөрийн арга замыг боловсруулахад туслах

5. Хэл агуулгыг интеграцчилах арга зүй (Content Language Integrated Learning -CLIL)

Олон хэлт (хос хэлт) боловсрол

Олон хэлт (хос хэлт) боловсрол (Multilingual (bilingual) education) гэдэг нь анхан шатнаас нь эхэлж сургалтад хоёр буюу түүнээс дээш тооны хэлийг ашиглаж сургалт явуулах, боловсрол эзэмших үйл явц юм. Олон хэлт (хос хэлт) боловсрол олгохыг зорьж буй улс орнууд эх хэл дээр суурилсан олон хэлээр боловсрол олгох хөтөлбөрөөр хүүхдийн төрөлх эх хэл болон бусад гадаад хэл дээр сургалт явуулдаг бөгөөд энэ чиглэлийн онол арга зүйн судалгаа өргөн хийгдэж байна. Нөгөө талаар олон хэлт боловсрол нь зөвхөн сургалт, боловсролын асуудал биш бөгөөд нийгмийн олон хэлт харилцааг төр, олон улсын байгууллагуудын зүгээс дэмжих нь харилцан мэдээлэл солилцох, соёл хоорондын ойлголцол ба олон улсын харилцааг бэхжүүлэхэд дэмжлэг болно гэж үздэг.

Олон судалгаагаар боловсрол сургалтын хэлний үүрэг, ялангуяа төрөлх хэл нь хүүхдийн боловсрол болон танин мэдэхүйн хөгжилд хэрхэн нөлөөлөхийг авч үзсэн байна.

Судалгааны дүн нь хос хэлтэй байх (болох) нь хүүхдийн хэлний чадвар болоод боловсролд эерэг нөлөө үзүүлдгийг баталсан байх бөгөөд хүүхдүүд бага ангиасаа эхлээд хичээлийн жилийн турш хоёр ба түүнээс дээш хэлээр ур чадвараа хөгжүүлж байгаа нь тэдний хэлийг гүнзгий ойлгох, үр ашигтай хэрэглэх чадварыг зэрэг хөгжүүлдэг гэжээ.

Судалгааны ажлууд нь хоёр өөр хэлний тусламжтайгаар мэдээлэл боловсруулдаг (хоёр хэлтэй) хүүхдийн сэтгэхүй уян хатан байдгийг баталсан байна.

Энэ бүхнийг үндэслэн судлаачид дараах гол дүгнэлтийг хийжээ. Үүнд:

- Хос хэлтэй байх нь хүүхдэд хэлний чадварын давуу талыг бий болгодог.

- Хэлний ур чадварын хөгжил нь харилцан хамааралтай шинжийг агуулдаг.

Судлаач П.Тобарс төрөлх хэл дээр унших, бичих чадварыг хөгжүүлэхэд хоёр хэлтэй хүүхдүүд илүү сайн байдаг гэж үзээд сургууль хүүхдийн төрөлх хэлийг багаас нь дэмжих нь чухал бөгөөд үүнд хүүхдийн ерөнхий танин мэдэхүйн хөгжил, үгийн нөөц, ярианы чадвар зэрэг нь чухал болохыг онцолсон. Тэрээр төрөлх хэлний мэдлэг (ухамсар, танихуй) болон ур чадвар нь шинэ хэлэнд амархан шилжинэ. Гэхдээ үүнийг сурахад сургуульд ч, гэр бүлийн орчинд ч тодорхой хугацаа хэрэгтэй гэжээ. Хэрвээ эцэг эх, эмээ өвөө нар хүүхдийн эх хэл дээрх үзэл бодол, сэтгэлгээ, үгийн нөөцийг хөгжүүлэхээр түүх ярьж өгөх, эсвэл хүүхэдтэй янз бүрийн сэдэв, асуудлаар яриа өрнүүлж харилцан ярилцах зэргээр цаг хугацааг хамт өнгөрүүлэх юм бол хүүхэд сургуульд амжилттай суралцахын хамт хоёр дахь хэлийг эзэмшихэд бэлтгэлтэй байна гэж ойлгож болно.

6. Ялгаатай суралцахуйн арга зүй (Different learning - Differentiated instruction)

Ч. Оюунбилэг.СУИС-ийн багш

Ялгаатай суралцахуй гэж юу вэ?

Суралцагч бүр өөрийн гэсэн чадвартай, сонирхолтой, хэрэгцээтэй, хүсэл мөрөөдөлтэй. Суралцагчид зан төлөв, олж авсан туршлага, суралцах арга барилаараа ялгаатай. Тэд хөгжлийн онцлог, харагдах байдал, хэлэх, сонсох, харах, танин мэдэх, сэтгэл хөдлөл мэдрэмжээ илэрхийлэх чадвараараа харилцан адилгүй. Сурагчдын олонх нь бие даан суралцах чадвартай байхад, нөгөө хэсэгт нь бусдын дэмжлэг, халамж анхаарал шаардлагатай байдаг. Хүүхдэд олгох боловсрол нь хүүхдийн хувийн онцлог, авьяас чадвар, оюуны болон бие бялдрын чадварыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд чиглэгдсэн байна. Хүүхдүүд оюуны чадамж, биеийн хөгжлийн чадвар, хэл соёлын ялгаа, онцгой авьяас, ар гэрийн дэмжлэг, өөрийгөө удирдах, илэрхийлэх, өөртөө итгэлтэй байх, харилцах, бие даан суралцах

зэрэг ялгаатай чадваруудаасаа шалтгаалаад өөрийн хэрэгцээнд тохирсон боловсролын чанартай үйлчилгээг бүрэн дүүрэн авч чадахгүйд хүрдэг. Иймээс бүх суралцагчийн оролцоо, амжилтыг хязгаарлаж буй саад бэрхшээлийг арилгаж, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог чанаруудыг нь хүндэтгэсэн, тэдний сурах боломжийг дэмжсэн, уян хатан, олон хувилбартай арга хэлбэр бүхий сургалтын арга барилыг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Хүүхэд бүрийн өвөрмөц нандин онцлог, хэрэгцээ, сонирхлыг таньж, ойлгож, хүлээн зөвшөөрч, хөгжлийг дэмжиж, давуу талд нь суурилж ажиллах нь багшийн үүрэг. Иймд хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бүх хүүхдийг (хүйсийн ялгаа, хөдөлмөр эрхэлдэг хүүхэд, үндэсний цөөнхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зэрэг) боловсрол эзэмших тэгш боломжоор хангах, ялгаатай нөхцөл байдал (жендэр, нийгмийн гарал, угсаа, суралцах чадварын түвшнээс хамаарсан), ялгаатай хэрэгцээнд нийцсэн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дэлхий нийт чухалчилж байна. Сурахуй нь тодорхой мэдлэг, чадвар, туршлага эзэмших зорилго бүхий үйлдлээ ухамсартайгаар зохицуулах чадвар, танин мэдэхүйн процесс, зоригийн чанаруудыг шаарддаг. Иймээс суралцагч бүрийн хүсэл сонирхол, мэдлэг чадварын түвшин, сурах арга барилын онцлогийг харгалзан хичээлээ уян хатан, сонголттой, ялгаатай арга, хэлбэрээр төлөвлөж зохион байгуулснаар бид үр дүнд хүрнэ. Ялгаатай суралцахуй бол сурагчдын мэдлэгийн түвшин, мэдлэгийг хүлээн авах байдал нь өөр, мөн шинэ мэдээлэл болон чадварыг өөрийн сонирголоос шалтгаалан хүлээн авч боловсруулах аргын хувьд ялгаатай болохыг хэлж байна. Ялгаатай сургалтын арга нь сурагч бүрт зориулсан ганцаарчилсан хөтөлбөр биш, харин нэг ангид байгаа ялгаатай арга барил, мэдлэгийн түвшинтэй хүүхдүүд дундаас нийтлэг шинжүүдийг нь анзаарч танин, түүнийхээ дагуу тухайн хөтөлбөрийг сурагч бүрт хүрч байх хамгийн үр дүнтэй уян хатан арга хэлбэрээр боловсруулан ашиглах юм. Ялгаатай суралцахуйн онол, загвар

Хүснэгт 7.1. Ялгаатай суралцахуйн арга зүйн давуу болон сул тал

Давуу тал:	Сул тал:
- Сурагчдын сурах бэлэн байдал, сонирхол, мэдлэгийн түвшин, сурах арга барилын ялгааг тооцсоноороо бүх сурагчдад амжилттай сурах боломжийг олгодог. Ялангуяа суралцах чадвар өндөртэй, мөн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад илүү өндөр үр нөлөө үзүүлдэг. - Тухайн сургалтын материалыг ямар арга барилаар судлах сонголтуудыг сурагчдад олгосноор тэд сурах үйл явцад илүү хариуцлагатай ханддаг. - Сурагчид суралцах үйл явцтай илүү холбогдож, дэг журам, сахилга бат сайжирдаг.	- Ялгаатай суралцахуйн арга зүйг ашиглахад багшид төлөвлөх ажиллагаа ихэсдэг тул үүнд зарцуулах цагийн менежмент дээр асуудал үүсдэг. - Анги доторх сурагчдын ялгаа хэт их байх үед багшид хүндрэл үүсэх магадлалтай. - Судалгаа болон батлагдсан хөтөлбөрүүд дутмаг байдаг тул багш бүр бие даан бэлдэх шаардлага гардаг.

Кэрол Анн Томлинсон (Carol Ann Tomlinson)-ы загвар. Томлинсоны загвараар сурган хүмүүжүүлэгч нар хичээлдээ ялгаатай суралцахуйн аргыг агуулга, үйл явц, үр дүн, суралцах орчинд тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой гэж үзжээ. Танилцуулах шаардлагатай сургалтын агуулга, хөтөлбөр, сурагчидтайгаа холбогдож агуулгаа танилцуулах үйл явц, арга, эдгээрийн эцэст сурагчид юу сурч мэдсэн үр дүн зэрэг элементүүдийг сурагчдын онцлог ялгаатай байдалд тохируулан сонгох болон хамгийн уян хатан байдлаар хамгийн оновчтой зааварчилгаатай уялдуулах нь чухал.



6. Ганцаарчилсан сургалтын арга зүй /тэгш хамруулан сургах боловсролын жишээн дээр/

Ц. Цэвэгмид. Боловсролын хүрээлэн секторын эрхлэгч
Ганцаарчилсан сургалт

Ганцаарчилсан сургалт нь тухайн хувь хүүхдийн хэрэгцээ, хөгжих, сурах боломжийг

дэмжсэн сургалтын хэлбэр юм.

Ганцаарчилсан сургалт нь:

- Хүүхдийн хөгжлийн үнэлгээнд суурилан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах;
- хүүхдэд сургалтын чиглэл, агуулга, арга зүй, өөрийн үнэлгээ хийх боломж олгох;
- хувь хүүхдийн оюуны болон бие бялдрын хөгжил, бие даасан байдлыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн багш хүүхдийн хамтын үйл ажиллагаа явуулах;
- сургалтын үйл ажиллагаанд хувь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх тухай асуудал байна.

Ганцаарчилсан сургалтын зорилго нь хүүхдийн хөгжих, сурах, ахуй амьдралын үйл ажиллагаанд тулгамдаж буй бэрхшээлийг багасгах, боломжит дээд түвшинд хөгжүүлэхэд оршино. Ганцаарчилсан сургалтыг хэрэгжүүлэхэд багш, сургуулийн удирдлага, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн хамтын оролцоо үр дүнтэй байна.

Ганцаарчилсан сургалтын онцлог

• Ганцаарчилсан сургалтад хувь хүүхдийг хамруулах асуудлаар боловсролын байгууллагад эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүсэлт гаргасныг үндэслэн хамруулах /Ганцаарчилсан сургалтын бэлтгэл үед хүүхдийн хөгжих, сурах бодит боломжийг таньж мэдэх, хүүхдийн ялгаатай хэрэгцээ, хүүхдийн сонирхол, мэдлэгийн хүрээ, ахуй амьдралын нөхцлийг судлах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ), хөтөлбөрийг боловсруулах, мэдээллийг хүлээн авахад шаардлагатай сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг аудио, брайл, томсгосон шрифтээр бичсэн бичвэр материал, дохионы хэлний сурах бичиг, зурагт карт, үгт карт бэлтгэх гэх мэт/;

- Ганцаарчилсан сургалтыг зохион байгуулахад хувь хүүхдийн гэр бүл, эцэг эх,
- асран хамгаалагчид хүүхдийн хэрэгцээ, хөгжлийн түвшинг харгалзан туслалцаа,
- зөвлөгөө өгөх;
- Хүүхэд мэдлэгийг бүтээлчээр өөрийн оролцоотой эзэмших, бие дааж суралцах,
- сурснаа амьдралд ашиглах боломжоор хангах;
- Сургалтын орчин нь сурагч бие дааж суралцахад саадгүй байх боломжийг хангах;
- Эрэгтэй ба эмэгтэй сурагчийн хүйсийн онцлог, биеийн эрүүл мэндийн байдал
- зэргийг онцгой анхаарах;
- Хүүхэд өөрийн тухай эерэг өөдрөг имиджтэй болох;


Хүснэгт 8.1. Ганцаарчилсан сургалтын давуу болон сул тал

Давуу тал	Сул тал
• Хувь хүүхдийн бодит чадварыг үнэлгээ хийх, оношилгоо хийх, ГСТ, хөтөлбөрөөр хичээллэх боломжийг олгох боловсруулах /агуулга, арга зүй, тохируулгат сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ/;	• Хүүхдийн хэрэгцээ, сонирхол, хөгжлийн болон сурах чадварын түвшин харилцан адилгүй өөр байдаг тул ГСТ боловсруулах, арга зүйг төлөвлөхөд цаг хугацаа шаардах;

Инге Унтын ганцаарчилсан сургалтын загварыг авч үзье. Орчин үеийн нөхцөлд ганцаарчилсан сургалт нь сургууль ба гэр бүл, байгууллагад суурилсан сургалтын хэлбэрээр хэрэгжиж байна. /Ганцаарчилсан сургалтын загвар нь:

Бие даасан ажилд зориулсан сургалтын ганцаарчилсан даалгаврууд, хэвлэмэл дасгал ажлын дэвтэр, ганцаарчилсан бие даасан ажлын зөвлөмж, ашиглаж байгаа ном, сурах бичигт дасан зохицох, бие даан хэрэглэх- эхний ээлжинд бусдын дэмжлэг авна.

Аажмаар дэмжлэгийг багасгана/. Хүүхдэд тухайн цаг мөчид юуг хийж чадах боломжтой байна, түүнийгээ хийх боломж олгоно. Хүүхдийг нэг хэвийн үйлийг олон хийснээс дургүйцэх, залхах байдалд орохоос урьдчилан сэргийлж, шинэлэг, нэмэлт үйлийг төлөвлөж хийлгэх боломжийг олгоно. Сургалтын агуулгыг давталттай, хүүхэд төвтэй идэвхтэй сургалтын арга зүйгээр явуулахад үр дүнтэй байна.



Зураг 8.1. Ганцаарчилсан сургалтын загвар